



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2020/134/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2020 он

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Гүнжидмаа

Утас: 260512 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Ахлах аудитор: Ж.Болормаа

Утас: 261628 Цахим хаяг: bolormaaj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

Аудитын гэрчилгээ	2
Аудитын тайлан	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
2.12. Шилэн дансны мэдээлэл	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	8
Менежментийн захидал	9
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	11
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	11
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	16
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	17
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЭМДС	Эрүүл мэндийг дэмжих сан
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЕРӨНХИЙ
ЗАХИРАЛ Д.НЯМХҮҮ ТАНАА

2020.08.21 № 06/571
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2019 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлийн дүн бидний тооцсон материаллаг байдлын түвшингээс давсан нь “Хязгаарлалттай” дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд,

- Батлагдсан төсвийн цалингийн зардлыг 269,956.2 мянган, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 32,144.3 мянган төгрөгөөр зардлын эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулсан, 18,325.0 мянган төгрөгийн цалинг Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын зардалд бүртгэсэн,
- Эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх гэрээний дагуу 48,850.0 мянган төгрөгийг шилжүүлж барааг гэрээнд заасан тоо хэмжээгээр хүлээн аваагүй боловч орлогоор бүртгэсэн,
- Эм, эмнэлгийн хэрэгслийн 103,459.1 мянган төгрөгийн, хүнсний материалын 28,416.0 мянган төгрөгийн тендерийн бус худалдан авалт хийсэн зэрэг нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” 41 дүгээр зүйлийн 41.2.2-д “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтууд, санхүүгийн тайлагналын Оршин байх гэсэн батламж мэдэгдэлтэй тус тус нийцэхгүй байна.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.1. Оршил

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Ерөнхий захирал Д.Нямхүү танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 25-наас 2020 оны 02 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ж.Болормаа хариуцаж хэрэгжүүлэв.

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 2/352 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь олон улсын эрүүл мэндийн дүрэм, халдварт өвчинтэй тэмцэх Ази номхон далайн бүсийн стратегийн шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан, шинжлэх ухаан технологийн дэвшил, хүний нөөцийн тогтвортой хөгжлийг дэмжигч байгууллага байх юм.

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн үндсэн үйл ажиллагааны чиглэлийг халдварт өвчний хяналт, урьдчилан сэргийлэлт, тандалт судалгаа, оношлогоо, эмчилгээний асуудлыг үндэсний хэмжээнд удирдан зохион байгуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах үүрэг бүхий тусгай мэргэжлийн төв байгууллага байна гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус яамны мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Халдварт өвчин судлалын үндэсний төв нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Санхүүгийн тооцоолох ХХК-ийн Acolous программ хангамж ашигладаг байна.

Төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Халдварт өвчин судлалын үндэсний төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 11 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 31,423,360.5 мянган төгрөгөөс тооцон 314,233.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулсан.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 406,317.9 мянган төгрөгөөр тооцсон нь төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь, хувь хэмжээг өөрчлөөгүй ч тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал өссөнтэй холбоотой болно.

2.8. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,555,959.4 мянган төгрөгөөр буюу 10 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материалын, биет бус хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	-	-	-
АВЛАГА	413,703.7	127,155.9	(286,547.84)
БАРАА МАТЕРИАЛ	11,741,520.6	13,596,319.5	1,854,798.91
Биет хөрөнгө	39,988,417.9	39,800,228.8	(188,189.12)
Биет бус хөрөнгө	10,625,733.0	2,689,711.7	(7,936,021.32)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	62,769,375.2	56,213,415.8	(6,555,959.4)
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		4,250.1	4,250.11
Засгийн газрын хувь оролцоо	20,296,448.8	12,361,327.4	(7,935,121.32)
Хуримтлагдсан үр дүн	8,295,778.9	9,670,690.7	1,374,911.85
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	34,177,147.6	34,177,147.6	-
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	62,769,375.2	56,213,415.8	(6,555,959.4)

Авлага дансны үлдэгдэл буурсан нь татаас санхүүжилтийн авлага буурсантай холбоотой боловч бохир ус сорох насос худалдан авах гэрээний дагуу Жодоо мод ХХК-д 39,000.0 мянган төгрөгийг шилжүүлж авлагаар бүртгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь тусгай зориулалтын материал, эм боох материал өссөнтэй холбоотой байна. Үүнээс, хандив тусламжаар 14,984,854.0 мянган төгрөгийн бараа материал хүлээж авсан байна.

Биет хөрөнгө хандив тусламжаар 1,942,773.2 мянган, төсвийн хөрөнгөөр худалдан авсан 14,429.8 мянган төгрөгөөр нэмэгдэж, хасагдсан хөрөнгө байхгүй.

Биет бус хөрөнгийн дансны үлдэгдэл буурсан нь өмнөх онд Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалын дагуу газрын эрхийн үнэлгээ хийхдээ газар ашиглалтын зориулалтыг буруу сонгосноос алдаа гарч тайлант онд 7,935,121.3 мянган төгрөгөөр бууруулж 2,687,086.6 мянган төгрөгөөр үнэлсэнтэй холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өссөн нь ХХОАТ-ын дутуу төлөлт тайлагнасан байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэлд буурсан нь газар эзэмших эрхийн дахин үнэлгээний бууралтаас шалтгаалсан байна.

2.9. ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Халдварт өвчин судлалын үндэсний төв тайлант онд 225,000.0 мянган төгрөгийн үйл ажиллагааны орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 244,362.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 109.0 хувиар биелүүлсэн байна.

Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 19,362.1 мянган төгрөгөөр давсан нь сайн дурын дархлаажуулалтын вакцины орлого нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх нийгмийн эрүүл мэнд, эмнэлгийн тусламж үйлчилгээ гэсэн 2 хөтөлбөрт зориулан 21,664,448.6 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас бараа, үйлчилгээний зардалд 21,484,625.6 мянган, урсгал шилжүүлэгт 179,823.0 мянган төгрөг зарцуулахаар батлагджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хүрээнд ЭМЯ-наас 1,210,382.7 мянган төгрөгийн хөрөнгө хүлээж авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 21,660,244.4 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа ч төсвийн гүйцэтгэлтэй уялдуулж төсвийн зардал хооронд гүйлгэн, төсөвт зохицуулалт хийсэн байна.

Нэмэлт төсөв: Хандив тусламжаар ДЭМБ-аас 1,779,896.6 мянган, Глобаль сангаас 197,974.6 мянган, өмнөх онд төвлөрүүлсэн 371,046.5 мянган, ЭМДЕГ-аас 285,400.0 мянган, ЭМДС-аас 462,350.0 мянган зэрэг нийт 3,767,937.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс дээрх байгууллагуудаас санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрт 3,764,161.1 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 3,775.9 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

2.10. АУДИТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 11 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 2 эрсдэл тодорхойлж нийт 13 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 578,062.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 17,158.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 48,850.0 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 341,425.5 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 170,629.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө. Үүнд:

1. Тусгай зориулалтын материал, эм боох материал, аж ахуйн материалын үлдэгдлийг бараа материалын орлого зарлагын журналтай тулган шалгахад 5,700.0 мянган төгрөгөөр бараа материалын ангилал хооронд гүйлгэн тайлагнасан, хүнсний материалын үлдэгдлийг 11,458.4 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь НББ-ийн тухай хуулийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад 17,158.4 мянган төгрөгийн алдааг залруулсан.

2. Энгүүн мед ХХК-тай хийсэн эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх гэрээний дагуу 48,850.0 мянган төгрөгийг шилжүүлж барааг гэрээнд заасан тоо хэмжээгээр хүлээн аваагүй боловч орлогоор бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтууд, санхүүгийн тайлагналын Оршин байх гэсэн батламж мэдэгдэлтэй тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн 48,850.0 мянган төгрөгийн акт тогтоосон.

3. Есөн мед ХХК-иас пульс оксиметр хэмжигчийг зах зээлийн үнээс өндөр буюу 21,000.0 мянган төгрөгөөр худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах 21,000.0 мянган төгрөгийн албан шаардлага өгсөн.

4. ХӨСҮТ-ийн захиргаа ҮЭХ-той байгуулсан хамтын гэрээний 3.1-д "... цалинг өнөөгийн хүрсэн түвшнээс бууруулахгүй аль болох нэмэгдүүлэх зарчим баримтална" гэж заасны дагуу Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоолоор баталсан цалингийн шатлал хоорондын зөрүү 84,530.2 мянган төгрөгийг сар бүр цалингийн зөрүү дансаар олгосонтой холбоотой цалингийн төсвийг 269,956.2 мянган, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг 32,144.3 мянган төгрөгөөр батлагдсан төсвийн зардлын ангилал хооронд гүйлгэн зарцуулсан, цалингийн 18,325.0 мянган төгрөгийн зардлыг ҮОМШӨ-ний даатгалын зардалд бүртгэсэн зэрэг нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.3-д "төсвийн гүйцэтгэл, зарцуулалт нь батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байгаа эсэхэд олон нийт хяналт тавих боломжоор хангах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах 320,425.5 мянган төгрөгийн албан шаардлага өгсөн.

2.11. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Дэлхийн зарим улс оронд гараад байгаа COVID-19 халдвараас урьдчилан сэргийлэхээр хэрэгжүүлж буй ажлуудын санхүүжилт, түүний зарцуулалтыг дараагийн аудитаар авч үзэх.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Халдварт өвчин судлалын үндэсний төв Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан ба хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланг байршуулаагүй байна.

2.13. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН АКТ, АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 31.13660 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоосныг бүрэн барагдуулсан, 34,292.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлсэн байна.

Алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Хязгаарлалттай” дүгнэлт

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөөг эс тооцвол санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгыг УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлснийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Цалингийн зардалтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Хавсран ажилласны нэмэгдэл нийт 38,753.9 мянган төгрөгийг үндсэн цалингийн 10-40 хувиар авдаг 11 ажилтны ажлын тайланг шалгахад тайлангаа өгөөгүй 3, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажил үүргийг 2 ажилтан хавсран гүйцэтгэж тус бүр 10 хувийн нэмэгдэл авдаг боловч ажлын тайланд энэ тухай дурдаагүй, ажлын тайлан хангалтгүй байна. Энэ нь байгууллагын удирдлагын зүгээс хавсран ажилласан ажлын тайланг хянаж гүйцэтгэлийг дүгнэдэггүй, хавсран ажиллах шаардлагатай ажлын байрны жагсаалт гаргаагүй, ажлын шаардлагыг тодорхойлж холбогдох тушаалд өөрчлөлт оруулаагүй байна.

1.2. Эрсдэл:

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, цалингийн зардал батлагдсан төсвөөс хэтрэх

1.3. Өгсөн зөвлөмж:

Хөдөлмөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-д “Ажил олгогч нь ... хөдөлмөрийн үр дүнд нь тохирсон цалин хөлс олгох, ... үүрэгтэй” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлээр танилцуулсан ба төсвийн захирагч хүлээн зөвшөөрч цаашид хэрэгжүүлж ажиллана.

2. Худалдан авалттай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Эм, эмнэлгийн хэрэгслийн 103,459.1 мянган төгрөгийн, хүнсний материалын 28,416.0 мянган төгрөгийн тендерийн бус худалдан авалт хийсний дотор зах зээлийн үнээс өндөр үнээр бараа худалдан авсан байна.

2.2. Эрсдэл:

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, зах зээлийн үнээс өндөр үнээр худалдан авалт хийх

2.3. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлээр танилцуулсан ба төсвийн захирагч хүлээн зөвшөөрч цаашид хэрэгжүүлж ажиллана.

3. Хөдөлмөрийн дотоод журамтай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2004 оны 77 дугаар тушаалыг үндэслэн Хөдөлмөрийн дотоод журмын 9.1-д "Хөдөлмөрийн хэвийн нөхцөлд ажиллаж байгаа ажилтны ажлын цаг өдөрт 8 цагаар тооцож 8:30-16:30 хүртэл, 7 хоногт 40 цаг ажиллана" гэж захиргааны албан хаагчдыг хамруулж ажлын цагийг амралтын цаггүй байхаар заасан байна.

3.2. Эрсдэл:

Илүү цагийн тооцоо бодитой бус гарснаар батлагдсан цалингийн төсөв хүрэлцэхгүй болох

3.3. Өгсөн зөвлөмж:

Хөдөлмөрийн тухай хуулийн 75.1-д “Ажилтанд амарч хооллоход нь зориулж завсарлага олгоно”, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2004 оны 77 дугаар тушаалын 2 дугаар зүйлийн 16, 4 дүгээр зүйлийн 27, 30-д заасан мэргэжлийн эмч, лаборант, жолооч, сувилагчаас бусад захиргааны албан хаагчдын ажлын цагийг хуульд нийцүүлэх арга хэмжээ авч ажиллах

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлээр танилцуулсан ба төсвийн захирагч хүлээн зөвшөөрч цаашид хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	12,155,224,273.02	13,723,475,346.32
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
33	АВЛАГА	413,703,716.79	127,155,875.94
33610	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	413,703,716.79	127,155,875.94
33300	Татаас санхүүжилт	371,046,510.00	2,680,425.00
33500	Бусад авлага	42,657,206.79	124,475,450.94
35	БАРАА МАТЕРИАЛ	11,741,520,556.23	13,596,319,470.38
35100	Түүхий эд материал	11,396,848,294.67	13,262,393,657.62
35110	Тусгай зориулалттай материал	1,346,636,896.54	2,009,034,603.74
35130	Эм боох материал	10,050,211,398.13	11,253,359,053.88
35400	Хангамжийн материал	344,672,261.56	333,925,812.76
35410	Бичиг хэргийн материал	3,297,964.00	5,472,613.60
35420	Аж ахуйн материал	76,598,100.51	101,861,713.54
35430	Сэлбэг хэрэгсэл	11,929,850.00	21,494,270.00
35440	Түлш, шатах тослох материал	200,000.00	320,000.00
35460	Хүнсний материал	26,471,451.57	22,891,590.00
35470	Бусад хангамжийн материал	226,174,895.48	181,885,625.62
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	50,614,150,923.89	42,489,940,488.68
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	50,614,150,923.89	42,489,940,488.68
39200	Биет хөрөнгө	39,988,417,923.89	39,800,228,808.68
39201	Барилга, байгууламж, орон сууц	36,368,655,921.94	36,368,655,921.94
39202	Хуримтлагдсан элэгдэл	(6,975,290.21)	(1,149,866,665.37)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,283,024,088.00	1,288,024,088.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(1,196,555,638.34)	(1,222,870,978.04)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	10,609,599,001.11	12,408,266,949.77
39206	Хуримтлагдсан элэгдэл	(7,437,413,086.95)	(8,321,454,707.11)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	994,735,234.65	1,148,270,390.59
39208	Хуримтлагдсан элэгдэл	(702,384,812.61)	(788,968,716.40)
39209	Зам, гүүрийн байгууламж	75,695,262.00	75,695,262.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(7,610,405.90)	(13,170,386.90)
39217	Ном	7,647,650.20	7,647,650.20
39300	Биет бус хөрөнгө	10,625,733,000.00	2,689,711,680.00
39301	Програм хангамж	10,774,750.00	10,774,750.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(7,249,750.00)	(8,149,750.00)
39305	Бусад үндсэн хөрөнгө / газар	10,622,208,000.00	2,687,086,680.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	62,769,375,196.91	56,213,415,835.00
	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	-	4,250,107.38
	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	-	4,250,107.38
413	Өглөг	-	4,250,107.38
4131	Ажилчидтай холбогдсон зардал	-	4,250,107.38
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	62,769,375,196.91	56,209,165,727.62
51	Засгийн газрын хувь оролцоо	20,296,448,769.60	12,361,327,449.60
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	20,296,448,769.60	12,361,327,449.60
51200	Хуримтлагдсан үр дүн	8,295,778,856.28	9,670,690,706.99

51210	Өмнөх үеийн үр дүн	4,556,327,643.28	8,295,778,856.28
51220	Тайлант үеийн үр дүн	3,739,451,213.00	1,374,911,850.71
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	34,177,147,571.03	34,177,147,571.03
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	62,769,375,196.91	56,213,415,835.00

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	/төгрөгөөр/ Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	35,162,811,745.35	42,006,706,484.34
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	14,035,590,355.86	17,170,367,294.34
120	Нийтлэг татварын бус орлого	14,035,590,355.86	17,170,367,294.34
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	14,035,590,355.86	17,170,367,294.34
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	171,053,055.00	168,893,660.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	36,816,945.00	73,846,371.70
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	13,827,720,355.86	16,927,627,262.64
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	21,127,221,389.49	24,836,339,190.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	18,513,147,500.00	20,185,491,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	18,513,147,500.00	20,185,491,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,536,303,261.49	3,396,890,590.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,130,584,439.49	2,311,725,978.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	251,857,100.00	489,892,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	153,861,722.00	595,272,212.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,077,770,628.00	1,253,957,500.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,077,770,628.00	1,253,957,500.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	31,155,350,182.57	40,597,501,733.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	31,155,350,182.57	40,597,501,733.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	30,737,657,934.57	40,386,647,522.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	10,343,820,184.92	12,128,825,566.05
210101	Үндсэн цалин	10,057,589,228.42	9,614,590,760.05
210102	Нэмэгдэл		567,444,866.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	34,396,265.00	582,835,000.00

210104	Урамшуулал	251,834,691.50	1,363,954,940.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,286,849,601.14	1,535,880,429.21
210201	Тэтгэврийн даатгал	796,802,136.36	1,019,087,194.19
210202	Тэтгэмжийн даатгал	99,600,266.67	114,022,393.50
